

3.4 Заадаг хичээл

Багшийн заадаг хичээлийн мэдээлэл оруулах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **БУ системийн Багш** үйл ажиллагааг сонгоно.
2. Багшийн жагсаалтаас заадаг хичээл оруулах багшийн нэрийг сонгоно.
3. Үйлдэл цэснээс **багшийн мэдээлэл** үйлдлийг дарна эсвэл жагсаалтаас багшийн нэр дээр дарна.
4. Багшийн мэдээлэл цонхноос Заадаг хичээл цэс рүү орно.
5. Мэдээлэл засах товч дарна.
6. Хичээл нэмэх товч дарна.

Д/д	Судлагдахуун	Хичээл	Хичээлийн ангилал
1	Математик	Математик 1 (MAT100)	Ердийн хичээл
2	Англи хэл	Англи хэл 10	Ердийн хичээл

Судлагдахуун	Заадаг хичээлийн чиглэлийг сонгоно. Жишээ нь ахлах бүлгийн математикийн хичээл заадаг бол судлагдахууныг математик гэж сонгоно.
Хичээл	Заадаг хичээлийг сонгоно. Жишээ нь ахлах бүлгийн монгол хэлний хичээл заадаг бол монгол хэл сонгоно. Хэрэв заадаг хичээл сонголтод байхгүй бол Хичээл хэсэгт заадаг хичээлийг үүсгэж, Хөтөлбөр, төлөвлөгөө хэсэгт хичээлийг нэмж оруулах шаардлагатай.
Хичээлийн ангилал	Хичээл хэсэгт хичээлийг үүсгэхэд хичээлийн ангилал талбарт сонгосон үзүүлэлт харагдана. Засах боломжгүй байна.
Хичээл нэмэх	Багшийн заадаг хичээлийг тодорхойлохдоо энэ үйлдлийг ашиглана. Хичээл нэмэх үйлдлийг дарахад

мөр нэмэгдэх бөгөөд заадаг хичээлийг тодорхойлно.
Хэрэв багш нэгээс олон хичээл заадаг бол хичээл
нэмэх үйлдлийг дахин дарж үүссэн хоосон
талбаруудад заадаг хичээлийг тодорхойлно.